

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-24

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 5-24

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 10 дугаар сарын 23-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Ундрам, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Ч.Анар.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, мөн яамны Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга Д.Батбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, И-Монгол академи УТҮГ-ын дарга Б.Мягмарнаран, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Үндэсний дата төв УТҮГ-ын дарга М.Баттулга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирал С.Жавхлан, Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал Ж.Энхбат, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ажилтан В.Батбаяр, Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын дарга З.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Л.Соронзонболд, А.Ганбаатар, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Үндэсний дата төв УТҮГ-ын дарга М.Баттулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Цагаанхүү, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Ч.Золбаяр, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Золжаргал: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/ төслийн төсөвт өртөг 4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 4 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 17.1.3.1-д тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 24 тэрбум төгрөг, санхүүжих дүн 24 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 4 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх /Улсын хэмжээнд/ төслийн төсөвт өртөг 5 тэрбум төгрөг, санхүүжих дүн 5 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 18.1.1-д тусгагдсан Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213 тэрбум төгрөг, санхүүжих дүн 213 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 5 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр /Улсын хэмжээнд/ төслийн төсөвт өртөг 2.59 тэрбум төгрөг, санхүүжих дүн 2.59 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 17.1.3.1-д тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 24 тэрбум төгрөг, санхүүжих дүн 24 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 2.59 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mm” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх төслийн төсөвт өртөг 1.2 тэрбум төгрөг, санхүүжих дүн 1.2 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1-д тусгагдсан Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/, төсөвт өртөг 15 тэрбум 645 сая төгрөг, санхүүжих дүн 15 тэрбум 645 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 1.2 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 22 минут үргэлжилж, 13 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 76.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
16 цаг 13 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг айлтгая.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирц 61,5 хувьтай бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя.

Энхбаярын Батиугар гишүүн 11 дүгээр тойрог, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, жагсаалт, ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Тогтмолын Мөнхсайхан гишүүн, Засгийн газрын гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн. Ингээд 61,5 хувьтай ирц танилцууллаа.

Ингээд ирц бүрдсэн учраас Байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл. Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулттай гишүүн байна уу? Асуулттай гишүүн байхгүй байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэндээ танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулга хийнэ. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Цэндийн Баатархүү ирнэ. Ингээд Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулга хийнэ. Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од дарга ирсэн байна. ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газар, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтын Энхболд. Би нөгөө газраар нь танилцуулчихсан. Орж ирэхээс нь өмнө учраас уншаад явж байгаа шүү. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал дарга байна. Цахим хөгжил, инновац, Харилцаа холбооны яамны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цагаанхүү. Цагаанхүү дарга ирсэн байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батчулууны Бат-Өлзий дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Батжаргал, мөн яамны Эдийн засаг, санхүү, төсөв хөрөнгө оруулалтын газрын дарга Энхтөр, ЗТЯ-ны Авто замын бодлогын зохицуулалтын газрын дарга Болор-Эрдэнэ. Тэгээд Сангийн яам, ЗТЯ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яам, ингээд холбогдох байгууллагууд, И-Монгол академи, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төв, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Радио телевизийн үндэсний сүлжээ, Мэдээлэл холбооны сүлжээ компани, Харилцаа, холбооны зохицуулах хороо, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан I дүгээр орлогч, НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхжсин.

Ийм өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна. Та бүгдийг цаг гаргаж хүрэлцэн ирсэнд баярлалаа. Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Одоо 25 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг орж иртэл ингээд түр хүлээж байя.

Жавхлан сайдын микрофоныг нээж өгнө үү.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа 2050, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, татвар төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформыг хийж, эдийн засгийн суурийг тэлж, хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлиггүй шаардлагатай байна.

Ирэх 2025 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд зайлиггүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутаг бие даан хөгжихөд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс онцлогтой юм.

Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33,9 их наяд төгрөг, суурь зарлага 32 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,9 их наяд төгрөгийн ашигтай байхаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ж.Золжаргал: Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын

Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 6 номерын микрофон нээж өгнө үү.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2015 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж, гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж, үнэлэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь зүйлүүдийг шийдвэрлэж эхлэх урьдчилсан хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864,7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35,6 хувь, нийт зарлага 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909,5 тэрбум төгрөг буюу төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930,5

тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн эрхлэн захирагчдын төсвийн багцыг дараах байдлаар төлөвлөжээ.

1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 129,1 тэрбум.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд 312,3 тэрбум.

Төсвийн эрх эрхлэн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын багцын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0,1 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 170,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

-Цахим хөгжлийн нууц харилцаа холбооны сайдын урсгал зардлын төсвийг 19,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 90,1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 6,6 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,1 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 4,9 тэрбум, мэдээллийн технологийн эрчимт үйлчилгээний зардлыг 1,8 тэрбум, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,2 тэрбум, Засгийн газрын урсгал шилжүүлгийн 1,1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 6 төсөл, арга хэмжээнд нийт 39,1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 3 төсөл, арга хэмжээнд 241,6 тэрбум төгрөгийг

гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын урсгал зардлын төсвийг 19 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 109,7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь эд хогшил, урсгал засварын зардлыг 0,7 тэрбум, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хураамжийг 8,4 тэрбум, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 9,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 4 төсөл, арга хэмжээнд нийт 202,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 7 төсөл, арга хэмжээнд 33,9 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Золжаргал: Загджав даргад баярлалаа.

Ингээд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргэсэн байгаа.

Тэгээд асуулт асуух хэсэгтээ оръё. Асуулт асуухдаа гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асууна. Нэмэлт асуух хугацаа 1 минут, хариулт шаардлагагүй гэж юу хангалтгүй гэж үзвэл 1 минутын нэмэлт асууж тодруулах боломжтой байгаа.

Асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ингээд Пунсалмаа гишүүнээр хаалаа. Цэнгүүн гишүүн асуултаа асууна уу?

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас гаргасан бас нэг энэ төсөв дотор нэг зүйл анхаарал татаад байна л даа. Тэгэхээр энэ зүйл нь болохоор Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан гээд байгаа юм. Тэгээд энэ Баатархүү сайд томилогдохоос өмнө 24 оны 3 сард жишээ нь тендер ингээд зарласан байгаа юм л даа.

Тэгээд тэр тендерийг нь ороод харсан чинь болохоороо нэг ийм юм байгаа байхгүй юу. Энэ тендерт оролцох юм бол ингээд л янз бүрийн контентууд үйлдвэрлэнэ гээд. Тэгээд хэрвээ энэ тендерт оролцох юм бол Соёл урлагийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан, ШУТС, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан зэрэг ижил төстэй сангуудаас санхүүжилт авч болохгүй гээд гаргаад өгчихсөн байгаа юм.

Тэгээд ер нь зүгээр ингээд хараад үзэхээр жишээ нь 25 оны төсөв дээр 1,9 тэрбумыг энэ Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан гэдэг дээр оруулаад өгчихсөн байгаа юм л даа. Тэгээд бусад бас зөндөө ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа сангууд бас байгаад байгаа юм. Тэгээд энэ сангуудын нийлбэр дүнг нь бодоод үзэх юм бол үнэхээр Монгол Улсад ач холбогдлын хувьд хэрэгтэй байгаа зүйлүүд үү, үгүй юу гэдгийг бид нар бодох ёстой.

Нөгөө талдаа өмнө нь тэгвэл энэ сангууд үйл ажиллагаа явуулж байсан бол үнэхээр тэр өргөн нэвтрүүлгээрээ яг ямар бүтээмж, яг үнэхээр яг ямар зорилтод хүрсэн юм гэдгийг хянаж үзсэн юм уу? Тэрийг ингээд харж байж шийдэхгүй бол бид нар ийм сонин үрэлгэн төсөв батлаад байгаа нь ард иргэдийг

төдийгүй ер нь зүгээр Монгол Улсын хөгжлийг ч гэсэн хойш нь татаад байна шүү дээ. Тэгээд ингээд харахаар бид нар ингээд эрчим хүчний реформ ч юм уу, том асуудлуудаа шийдье гээд ингээд явж байхад бид нар ингээд хажуугаар нь улсын төсвөө танах ёстой байтал чинь ийм хэрэгцээгүй асуудлуудыг оруулж ирээд хэрэгцээгүй сангуудыг байгуулчихсан байгаад байна.

Ингээд хараад үзэхээр чинь энэ сангуудаар далимдуулж хэн ч буцаагаад нэг сан дээр зарлагдаж байгаа юу нь 19 сая төгрөгөөр л нэг төсөл байхаар байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь үнэхээрийн хэрэгтэй байсан уу, үгүй юү гэдгийг бид нар харах ёстой. 19 сая төгрөг ч гэсэн том мөнгө шүү дээ, яг үнэндээ бол.

Тэгэхээр ийм адилхан чиг үүрэг явуулаад яваад байгаа сангуудыг бид нар ер нь болиулах шаардлагатай байгаад байна. Тэгэхээр яагаад бид нар энэ дээр жишээ нь 1,9 тэрбумыг ахиад батлаад явах ёстой юм гэдгийг асуумаар байна. Тэгээд ер нь ахиад л бас нэг сонин юманд орж ирэх байх. Бүх гишүүд л хэлж байгаа. Хэрэгцээгүй төсвүүд байгаад байна шүү дээ, үүнийгээ таная гээд. Тэгэхээр үгүй ээ, одоо ингээд төсөв өргөн барьчихсан байна. Бид нар одоо бол дуусгах боломжгүй гэж ингэж хэлээд байгаа юм. Гэхдээ ер нь зүгээр ингээд шинээр Улсын Их Хурал бүрэлдээд явсан юм бол бид нар ганцхан хэлээд өнгөрдөг биш, үүнийгээ бас үнэхээр зогсоож чаддаг, хэрэгцээтэй төслүүд рүүгээ юмаа оруулдаг байх хэрэгтэй байгаа юм. Ер нь зүгээр төр өөрөө иргэдийн халааснаас татвар зэргээр маш хүнд дарамт болгож, мөнгө цуглуулж авчхаад, ийм хэрэгцээгүй сангуудыг ажиллуулаад баймааргүй байна.

Ж.Золжаргал: Өргөн нэвтрүүлгийн сангийн талаар хариулт өгье. Хэн өгөх вэ? Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас. 4.

Сайд уу? 4 номерын микрофон нээж өгнө үү.

Гишүүний асуултад хариулъя.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Алтан-Од. Энэ сан маань Цэнгүүн гишүүн ээ. Ер нь энэ сая 1 сарын 1-нээс байгуулагдаж үйл ажиллагаа нь эхэлсэн. Шинэ тутам байгуулагдсан. Өнгөрсөн онд хууль журам гарч байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхлэх гэж байсан болов чиг эхний улиралдаа үйл ажиллагаа явж төлөвлөгөө батлагдсан байх худалдан авалтын ажиллагаа зохион байгуулагдсан байхаар ийм журамтай, Засгийн газраас баталж өгсөн.

Тэгэхээр энэ хугацаандаа төлөвлөлт, шинэ журмынхаа биелэлт дээр яамнаас хугацаандаа амжаагүй байсан учраас журмын биелэлтээ хангах ийм боломжгүй байдал үүссэн. 1,9 тэрбум төгрөгийн сан дээр хөрөнгө тавигдсан байдаг. Ингээд 4 сард төлөвлөлтөө хэрэгжүүлээд, таны хэлдгээр 19 сая төгрөгийн төсөвтэй ажлуудад объёмыг нь хуваагаад хэрэгжүүлье гэсэн болов чиг хөндлөнгийн байгууллага АТГ-ын шалгалт орж ирээд үүнийг цаашид ингэж явуулах боломжгүй юм байна. Засгийн газраар журмаа оруулах байдлаар цаашид бас анхаарч ажиллаарай гэсэн зөвлөмж өгсөн байдаг.

Ж.Золжаргал: Цэнгүүн гишүүн тодотгол нэмэлт асуулт.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ чинь ингээд харагдаж байна шүү дээ. Өмнө нь 2024 оны 1 сард энэ сан байдаггүй байж байгаад, шаардлагагүй зүйлсийг бид нар ингээд ахиад гаргаад ирчихсэн. Одоо ингээд Баатархүү сайдын, энэ Баатархүү сайдаас хамаарахгүйгээр ороод ирчихсэн байгаа төсөв байгаа байхгүй юу. Тэгээд байж байтал буцаагаад л үр дүнг нь шалгах, яах ийх болоод ирэхэд энэ асуудлаа бид нар ер нь цаашид нь маш нухацтайгаар хандаад,

үр бүтээмж дээр нь суурилж, энэ асуудлуудыг хянадаг байх ёстой юм. Баатархүү сайд ч гэсэн сайн тодруулгуудаа хийж яваарай. Яагаад гэхээр энэ өөртэй чинь хамааралгүй байдлаар иймэрхүү сонин төсвүүдийг баталчихсан. Тэрийг нь та хийсэн юм шигээр харагддаг болох вий дээ гэдгээс би болгоомжилж байна.

Ж.Золжаргал: Баярлалаа. Өргөн нэвтрүүлгийн сан гээд ер нь нэлээн бас шуугиантай сэдэв байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас анхаарах нь зөв болов уу даа.

Дараагийн нэмэлт хариулт, хэлэх үү? Баатархүү сайдын зүгээс, яамны зүгээс. Болсон гэж үзсэн. Баатархүү сайд нэмэлт хариулт өгье. Баатархүү сайдын микрофон.

Ц.Баатархүү: Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа энэ сангуудын зарцуулагдах зориулалт, үр ашгийн шинжилгээг хийе гэдэг Улсын Их Хурлын гишүүдийн саналтай санал нэг байгаа. Өргөн нэвтрүүлгийн сан маань орон нутагт алслагдсан бүс нутагт ажиллаж байгаа өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ явуулдаг, тэгээд контент бэлддэг, тэр дундаа Монгол хүүхдийн төлөөх энэ контентыг бэлдэхэд нь туслах зорилготой ийм санг Өргөн нэвтрүүлгийн холбооны зүгээс санаачилж энэ санг байгуулсан. Сангийн журам дээр сангийн үйл ажиллагааг 1 дүгээр улиралдаа багтааж дуусгана гэдэг ийм журамтай юм байна лээ.

Тэгээд нөгөө 1 дүгээр улирал нь өнгөрчихсөн учраас сангийн үйл ажиллагаа дээрээ ямар нэгэн зохион байгуулалт хийж болохгүй байсан учраас сангийн журмыг дахин Засгийн газрын асуудлаар, Засгийн газрын хурлаар хэлэлцээд ер нь энэ сангийнхаа асуудлыг яах юм бэ гээд байдлаар Засгийн газарт сангийнхаа журамд хугацааны өөрчлөлт оруулчхаж байгаа юм. Ямар хугацааны ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмээд 1 минут өгчихье.

Ц.Баатархүү: Тэр нөгөө бүх нийтийн үйлчилгээний сан шүү дээ, тэр чинь. Бүх нийтийн үүргийн, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан чинь өөр сан. Өргөн нэвтрүүлгийн сан чинь өөр сан. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг манайхан бас андуурч хольж хутгаад байдаг. Тэр бол төрийн татвар төлөгчдийн юм уу төсвийн мөнгөөр бүрдээгүй. Хувийн хэвшилүүд алслагдсан бүс нутагт шаардлагатай харилцаа холбооны дэд бүтцийг бий болгох зорилготой ийм сан байдаг. Энэ нь өөр сан. Гэхдээ Байнгын нөгөө хууль хяналтын байгууллага энэ сангийн үйл ажиллагаа дээр хяналт дүгнэлт хийгээд бас үйл ажиллагаа дээр нь чиглэл өгөөд явж байдаг ийм сангууд байгаа шүү. Манай дээр ийм 2 сан байдаг.

Ж.Золжаргал: Баярлалаа. Засгийн газрын гишүүний хувиар Номин сайд нэмэлт хариулт өгье гэж байна. Микрофон нээж өгнө үү. Номин сайдын микрофоныг нээж өгнө үү.

Ч.Номин: Сайн байцаана уу? Энэ Өргөн нэвтрүүлгийн сангийн хувьд болохоор бас манай салбартай шууд холбогдолтой учраас би бас нэмэлт тайлбар хийчихье гэж бодож байна.

Ер нь сүүлийн үед бид нар энэ бусад улсын соёлын довтолгоонд маш их автаж байгаа. Энэ хийгдэхдээ илүү энэ контентоор дамжиж буюу илүүтэй дижитал дээр байгаа болон телевизүүдээр гарч байгаа энэ контентоор дамжиж хийгдэж байгаа. Тэгээд энэ ч утгаараа энэ Өргөн нэвтрүүлгийн сан дээр орж ирж байгаа гол зүйл юу вэ гэхээр Монгол хүүхдийг Монгол болгож өсгөх, Монгол агуулгатай, Монгол хэл дээрх контентуудыг нэмэгдүүлэх, үүнээс гадна түүх, соёлоо өвлөн уламжлуулах шаардлагатай түүхийн агуулгатай контентуудыг нэмэгдүүлэх хүрээнд энэ

сангийн зарцуулалт нь бий болох нь шаардлагатай байна гэж үзсэн учраас орж ирсэн ийм сан байгаа.

Ж.Золжаргал: Нэмэлт асуултыг дараа нь тодруулга авъя. Хугацаа дууссан учраас. Ингээд Соронзонболд гишүүн асуултаа асууна уу.

Л.Соронзонболд: 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт дээрээс хэдэн асуулт асууя.

1 дүгээрт, энэ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 36.1.5 дээр 1.1.5 дээр төрийн мэдээлэл солилцооны Хур системд хувийн хэвшлийн байгууллагыг холбох гэж орсон байна. Энэ ямар ажлууд төлөвлөгдсөн бэ? Цаад хувийн хэвшлийн байгууллагуудад бас холбогдох зардал гарна. Тэр зардлыг бас энэ төсөвт тусгагдсан байгаа юу гэж, 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт болохоор энэ Инноацийн, өндөр технологи, инновац бизнес хөгжлийн төв байгуулна гэж 36.1.3.1 дээр орсон байна. Гэтэл МУИС, ШУТИС гээд олон энэ сургуулиуд руу бас ийм инноацийн хөгжлийн төвүүд байдаг. Эдгээр төвөөс юугаараа ялгаатай байх вэ, үр дүн нь гол нь юу байх вэ гэсэн ийм асуулт байна.

3 дугаар асуулт болохоор энэ Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын ажлын хүрээнд энэ 18.3.1.3 дээр шинжлэх ухаан, технологийн үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ гээд ийм зорилт тавьчихсан байгаад байгаа юм. Энэ дээр яг үнэхээр шинжлэх ухаан, технологийн үр дүнгээр оюуны өмчийг эргэлтэд оруулахад хэдий хэмжээний тодорхой хэмжээний борлуулалт, тэгээд бодитой мөнгөн дүнтэй л ийм зорилт байх ёстой юм биш үү л гэсэн нэг ийм асуулт байна. Яагаад

гэхээр энэ дээр 16 байсныг 25 болгоно л гээд тавьчихсан байгаад байгаа.

Дараа нь болохоор 4 дүгээр асуулт буюу байна гэхээр энэ төсвийн дэлгэрэнгүй задаргаа дээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны төсөв дээр шинээр хөдөөгийн багийн үүрэн холбооны сүлжээг сайжруулах дээр төсөв байхгүй юм байна гэж ойлголоо. Яагаад гэхээр энэ дээр байгаа үзүүлэлтүүдийг харахаар дандаа 2024 онд эхэлсэн ажлуудын л төсөв байна гэж ойлгож энэ зөв үү гэж нэг асуулт байгаад байна.

5 дугаарт нь болохоор энэ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын энэ 20.3.2 дээр нэг 10 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг тусгасан байна л даа. Энэ ямар тоног төхөөрөмж бодож авах гэж байгаа вэ гэсэн ийм асуултууд байна.

Ж.Золжаргал: Эхлээд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаас хариултууд өгөх үү? Баатархүү сайдын микрофон нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Соронзонболд гишүүн маш олон зөв асуултуудыг хөндөж байна.

1 дүгээрт нь, Монгол Улс энэ инноацийн эко системийг бүрдүүлж, гарааны компаниуд үсрэнгүй хөгжил хийж, бидний хэлдгээр дэлхийд өндөр үнэлгээтэй Юникорн компани байгуулах, энэ дижитал эдийн засгийг бүтээх бол одоо салбарын хамгийн том зорилтуудын нэг болчихоод байгаа юм. Олон жил бид нар энэ старт апуудыг дэмжихийн тулд Хаб-уудыг ажиллуулъя, хувийн хэвшлийг оролцуулъя, их сургуулиудыг оролцуулъя гэж үзсэн боловч харамсалтай нь Хаб-ууд төрөлжөөд эхэлсэн. Одоо байгаа Мэдээлэл технологийн паркууд дээр явж байгаа яг энэ хиймэл оюун ухааныг ч юм уу, блокчэйн технологийг дэмжих гэхээр эрчим хүч нь илүү зарцуулагддаг,

интернэтийн хүчин чадал нь их байх ёстой.

Тэгэхээр бид нар Төв аймагт шинээр энэ хиймэл оюун ухааны старт апуудыг дэмжсэн ийм мэдээлэл технологийн Хаб-ыг төрөлжүүлж байгуулъя гэдэг урьдчилсан байдлаар ийм төсвийг тавьсан байгаа гэдгийг хэлье ээ.

Нэмээд манайхан тэр хур системтэй холбоотойг Баттулга дарга хариулчих уу? Үндэсний дата төвийн дарга Баттулга дарга нэмээрэй. Ер нь манай бүх харьяа газрууд ирсэн учраас хариултаа маш тодоор тодорхой сайн өгнө шүү. Соронзонболд гишүүний асуултад.

2 дугаарт нь энэ өнгөрсөн жил 100 орчим цэгт одоо бол 136 цэгийн байршил дээр хөдөлгөөнт холбоо зайлшигүй тавиагч ээ гэдэг Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтийн дагуу өнгөрсөн жил 100 цэгийн ажил эхэлсэн. Зарим цэгийн ажлууд нь эхлээд явж байгаа. Зарим цэгүүд нь он дамжаад явж байгаа гэдгийг дахиад тайлбарлая, хэлье гэж бодож байна.

Ж.Золжаргал: Баттулга дарга хэдэн номер дээр сууж байна. 6 номерын микрофон нээж өгнө үү.

М.Баттулга: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Үндэсний Дата Төв дээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Яамнаас баталж өгсөн журмын хүрээнд иргэн, хуулийн этгээдэд 11 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа.

Мөн мэдээллийн, хүний хувийн мэдээлэл хамгаалах, Нийтийн мэдээлэл, ил тод байдлын тухай хуулиар мөн тодорхой чиг үүргүүдийг оноосон. Энэ хүрээнд иргэн, хуулийн этгээдэд төрийн байгууллагуудад үйлчилгээг үзүүлж ажиллаж байгаа. Үүний дагуу өнөөдөр Үндэсний Дата төвөөс үзүүлж байгаа үйлчилгээнээс төрийн цахим үйлчилгээ,

цахим системүүдийн бараг 90 гаруй хувь нь шууд хамааралтай ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай буюу дэд бүтцийн эрдэнэтант байдлыг хангах зорилгоор энэ улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр 11,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг тусгасан байгаа. Энэ маань дата төв дээр байгаа яг нэн чухал системүүдийг дэд бүтцийн ямар нэгэн байдлаар гэмтэл ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт авах юм уу? Та. Нэмэлт 1 минут 6 номер.

М.Баттулга: Ямар нэгэн байдлаар гэмтэл, саатал гарах, мөн техникийн засвар үйлчилгээ хийх тохиолдолд сэлгэн ажиллах байдлаар, ажиллахаар ингэж төлөвлөсөн хөрөнгө оруулалт байгаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. ШУТС-тай холбоотой асуултууд дээр хаанаас хариулах вэ? 9 номерын. 9 номерын микрофон нээж өгнө үү.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын хэлтсийн дарга Урьболд байна. Гишүүний асуултад хариулъя.

Инновацын тухай хууль болон Оюуны өмчийн тухай хуулиар оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ гэсэн зохицуулалт байдаг. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэд ШУТС байдаг. Энэ сан нь технологи, инновацын төслүүд болон суурь судалгаануудын төслүүдийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Тэгээд ирэх жилийн хувьд 9 технологи, инновацын төсөлд эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэхээр ийм зорилтыг дэвшүүлсэн байгаа.

Ж.Золжаргал: Тэр 9-ийг нь та тодруулаад хэлчхэж болох уу?

Б.Урьболд: Энэ болохоор журмын хүрээнд сонгон шалгаруулалт явуулаад, тэгээд оюуныхаа өмчийг авчихсан, бизнес төлөвлөгөөгөө боловсруулсан төслийг шинжээчийн сонгон шалгаруулалтаар ороод, тэгээд крантад хэлбэрээр санхүүжүүлэх ийм төслүүд байгаа.

Ж.Золжаргал: Соронзонболд гишүүн та хариултаа авсан.

Баярлалаа. Амгаланбаатарын Ганбаатар гишүүний асуултыг, микрофоныг нээж өгнө үү.

А.Ганбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгээд Баатархүү сайдаас нэг бодлогын чанартай нэг асуулт байна. Дараа нь нэг санхүүжилттэй холбоотой 2 дахь асуулт байна, 2 асуулт.

Ер нь яах вэ, Финлянд, Солонгос, Израил, Сингапур эд нар гээд энэ инновац, шинжлэх ухаан, технологио үйлдвэрлэлд оруулаад зах зээлд ашиглаад нийгмийн өгөөж болгоод явж байгаа орнууд зөндөө байна л даа. Тэгээд энэ өмнөх 7 хоногт бас Сингапурын зарим нэг төлөөлөгч нартай бас нэг уулзах завшаан тохиолдоод ярьж байхад энэ шинжлэх ухааны бодлого, инновац 2-ыг нэг байлгадаг. Яамны бодлогоор нэг байдаг гээд. Одоо манайд БСШУ гээд нэг яам, Цахим хөгжил, инновац гээд нэг ийм ахиад нэг яам. Өөрөөр хэлбэл бодлогын ийм салаа гараад ирж байна л даа. Энэ дээр Баатархүү сайдаас асуух гэж байгаа нь бодлогын талдаа хүндрэл үүсэж байна уу. Энэ ер нь зөв байна уу гэж.

Доороо энэ янз бүрийн сангуудыг нь харахаар ШУТС энэ тэр гээд л сангаараа нийлээд байдаг, сиами ихэр шиг. Дээрээ яам нь салчхаад байгаа юм шиг, энэ бодлого нь салчхаад байгаа юм шиг харагдаад байх юм. Энэ дээр бэрхшээл үүсэж байна уу гэж. Эхний асуудал.

Дараагийнх нь энэ ШУТС гээд сая бид нар яриад байна л даа. Инновац, старт апуудаа дэмждэг тэр Эй ай хиймэл оюун ухаан, блокчэйн эд нар гээд энэ шинэ шинэ технологи, инновацуудыг дэмждэг, санхүүжүүлдэг сан чинь энэ юм биш үү? Би буруу ойлгож байж магадгүй. Гэтэл энэ 25 оны төсөл дээр тэг гэж байгаа байхгүй юу? 25 дээр би буруу хараагүй бол тэг хөрөнгө оруулалттай гээд. Энэ зөв байна уу. Үүнийг нэг тайлбарлаж өгөөч гэсэн ийм асуулт байна.

Ж.Золжаргал: Баатархүү сайдын микрофоныг нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Бидний үзүүлэлтээр үсрэнгүй хөгжиж байгаа улс орнууд бол судалгаа, инновац, шинжлэх ухаандаа дотоодын нийт бүтээгдэхүүний хээ тодорхой хувийг зарцуулдаг. Судалгаанаас 2-5 хувийг шинжлэх ухаан, инновац гэдэг талбартаа зарцуулж байж, улс орон хөгжих юм байна гэдэг ийм ойлголттой байдаг юм байна лээ.

Монгол Улсын хувьд энэ нь 0,2 хувь байна гэдэг ийм тоон статистик байгаа. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам бол төрийн энэ үйлчилгээг цахимаар иргэдэд үзүүлэхээс гадна дижитал эдийн засгийг бүтээх энэ эко системийг л бүрдүүлэх гээд байгаа юм.

Эдийн засаг, хөгжлийн яам бол салбар болгонд шинжлэх ухааны суурь тэр судалгаануудыг санхүүжүүлэх, тэр судалгаа нь өөрөө эхлээд суурь судалгаанууд нь хийгдээд, дараа нь хэрэглээнд нэвтрэх тэр био технологийн, нано технологийн, энэ олон технологиудын судалгаануудыг санхүүжүүлэх зорилготой сан нь бол ШУТС.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам бол юникорн буюу старт ап компаниудыг дэлхийд гаргах,

бойжуулах тэр бодлого руугаа илүү явдаг.

2 дугаарт, мэдээллийн технологийн цахим систем дээр гарч ирж байгаа шинэ технологиудыг салбар болгонд нь нэвтрүүлэхэд нь арга зүйн чиглэлээр туслалцаа үзүүлэх ийм зорилготой байдаг. Тэгээд энэ нь хиймэл оюун, блокчэйн юу байдаг юм ийм бусад технологиуд байж байгаа, веб 3 ч гэх юм уу. Гол бэрхшээл юу байна вэ гэхээр хангалттай хүний нөөц бидэнд байхгүй байна, хангалттай туршилага байхгүй байна.

Тэгэхээр бид гадаад хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна. Төрийн байгууллагууд уялдаатай байх хэрэгтэй байна, цахим хөгжил гэж тусдаа байхгүй юм байна. Бүх салбарын хөгжил, дэвшлийн суурь нь энэ дижитал шийдлүүд, мэдээлэл, технологийн шийдлүүд гарчихсан учраас бүх салбартай уялдаж байгаа учраас салбар дундын энэ мэдээлэл, технологийн хөгжлийн суурийг уялдуулах үүрэгтэйгээр яам ингэж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Ж.Золжаргал: Эдийн засгийн хөгжлийн яамнаас энэ дээр хэлэх зүйл, нэмж хэлэх зүйл байгаа юу байхгүй байна уу?

Дараагийн асуултаа авъя. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамнаас асууя даа. Энэ цалин хөлс, бүтэц, орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор төсөв нэмэгдэж байгааг ойлгож байна. Энэ дотор би сая тэр бүх нийтийн үүргийн үйлчилгээний санг асуух гэж байсан, бас сайд ерөнхийдөө хэллээ. Гэхдээ энэ нэг өсөлттэй харагдаад байна шүү дээ. 23 он, 24, 25 оны төсөв нь. Үүрэн холбооны компаниудын татвараар бүрддэг

татвар юм уу, хураамж юм уу. Одоо юугаар юм, бүрддэг гэж ингэж ойлгоод байгаа юм. Ингэж өсөлттэй байгаа нь юунаас шалтгаалж байгаа юм, 1 дүгээрт.

2 дугаарт, бид нар энэ хөдөө, орон нутагт энэ багуудын холбооны хөрөнгө оруулалтууд аягүй их яригддаг болсон. Алслагдсан багуудын харилцаа холбоо. Одоо байгаа энэ 24, 25 оны хөрөнгөөрөө 100 орчим цэг хийгдэж байгаа юм байна. Нэг 3 аймаг тусдаа хөрөнгө оруулалтууд хийгдэж байгаа юм байна. Энэ хөрөнгө оруулалтыг бодвол энэ 3-аас бусад аймгуудад нь хуваарилж байгаа байх.

Тэгэхээр шинээр орж ирж байгаа, санал өгч байгаа, үнэхээрийн хэрэгцээ шаардлагатай байгаа энэ орон нутгууд, энэ багууд дээр ямар бодлого барьж, ямар хөрөнгө оруулалт хийе гэж төлөвлөж байгаа юм. Энэ бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн энэ 8,3 тэрбум чинь ямар хөрөнгө оруулалт чиглэгдэх вэ. Энэ энэ багуудын холбоо руу зарцуулагдах уу гэдэг энэ асуултыг асууя.

Ж.Золжаргал: Баярлалаа. Баатархүү сайд микрофон нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бол зорилго нь алслагдсан хөдөө, орон нутаг, алслагдсан бүс нутаг, хилийн боомт, шинээр үүсэж байгаа хүн амьдарч байгаа тэр бүс, нутгуудад хөдөлгөөнт холбооны үйлчилгээг тасралтгүй өгөх үүрэгтэй ийм сан. Сангийн төвлөрүүлж байгаа мөнгө тодорхой хувиар нэмэгдэж байна гэдэг бол харилцаа холбооны салбар эрүүлжиж байна, энэ салбарын ашиг орлого нэмэгдэж байна гэж ойлгох хэрэгтэй. Энэ салбарын ашгийн тодорхой хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбооны компаниуд төвлөрүүлээд, өөрсдөө хяналтын зөвлөлтэйгөөр Монгол Улсын аль бүс нутагт дэд бүтцийг татах вэ гэдэг ийм шийдлийг гаргадаг. Өнгөрсөн туршилагаас харах юм бол Улсын Их

Хурлын гишүүдийн цаана байгаа сумын иргэд, багийн иргэд маань бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаар дэд бүтцийг шийдэж өгөөч ээ гэдэг хүсэлтийг Их Хурлын гишүүдээрээ дамжуулаад өгдөг учраас бид яг энэ зарчмаар цаашидаа зарцуулна.

Тэгэхээр 2025, 26 ондоо алслагдсан бүс нутгуудад хөдөлгөөнт холбоог энэ үүргийн сан, нэмээд улсын төсөв, энэ боомтын сэргэлтийн хүрээнд 14 боомтын асуудал байгаа. Боомтуудад зориулсан интернэтийн үйлчилгээг хүргэх ийм зайлишгүй шаардлагатайгаар бид нар үйл ажиллагаагаа явуулж байна гэдгийг хэлье.

Нэмээд Цагаанхүү дарга хариулаарай.

Ж.Золжаргал: 5 номерын микрофон нээж өгнө үү.

С.Цагаанхүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрхэм гишүүний асуултад хариулъя. 24, 25 онуудад үндсэндээ улсын дэд бүтцээр 100 багт сүлжээ оруулахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Энэ дээр нэмэх нь бид бүхэн нэг багийг 200 сая төгрөг, мөн үүргийн сангаар баг дээр үйлчилгээ оруулахаар 7,5 тэрбум төгрөгөөр тендер зарлаад авсан. Ингээд төр, хувийн хэвшил нийлүүлээд мөн баг дээр сүлжээ оруулахаар ингээд төлөвлөөд ажиллаж байгаа.

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүн та хариултаа авсан бол авсан уу, тийм ээ. Нэмэлт Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Тэр 7 аравны хэдэн тэрбум гээд ямар тоо ярьчихав. Тэр алинтай хамаатай тоо ярьж байна. Өөрөө сая.

Ж.Золжаргал: 5 номер.

С.Цагаанхүү: Энэ жилийн хувьд 24 онд 55 багт үйлчилгээ оруулахаар төлөвлөсөн. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан дээр төлөвлөсөн мөнгө байгаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Бүх нийтийн үүргийн сан буюу нөгөө Аж ахуйн нэгжүүдээс хуримтлуулсан тэр сангаас 57 байриил дээр төлөвлөж байгаа юм байна гэж ойлголоо.

Ингээд Пунсалмаа гишүүний асуултыг авъя. Пунсалмаа гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Би энэ бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Хиймэл дагуул хөөрөхтэй холбогдоод дахиад нэг асуулт асууя. Хиймэл дагуул хөөргөж байгаа энэ үйл явдал бол Монгол Улсын хувьд техник, технологийн дэвшлийн хувьд, нэг томоохон алхам болж байна гэж ингэж ярьж байгаа юм. Энэ томоохон алхам хийж байгаатай холбогдуулаад үүнийг бас өртөг зардал нэлээн өндөр байгаа. Энэ Францын Засгийн газраас зээлээр авч байгаа. Зээлээр авч байна гэдэг энэ буцалтгүй тусламж биш бид нар төлнө. Яг энэ утгаараа бид нарын энэ өнөөдрийн шийдэж байгаа энэ худалдан авалт иргэдэд яг ээлтэй, өгөөжтэй худалдан авалт байх уу, үгүй юү гэдгийг бид нар шийдэх ийм чухал үе дээрээ ирсэн байгаа.

Тэгэхээр зэрэг энэ хиймэл дагуулын энэ худалдан авалтыг манай энэ мэргэжлийн салбарын хүмүүс юу гэж үзсэн юм. Хуралдаад энэ үнэхээр одоо цаг үед байгаа хамгийн зөв сонголт юм. Энэ ирээдүйд өгөөжтэй юм. Энэ хамгийн одоо цагт сонгож байгаа зөв хэлбэр гэдгийг баталчихсан ийм хурлын протокол байна уу? Тэгвэл иргэд үзмээр байна. Бид нар үзмээр байна. Шийдвэр гаргаж байгаа хүмүүс хармаар байна, 1 дүгээрт.

2 дугаарт, бас нэг зүйл бол аливаа нэгэн энэ төрийн энэ томоохон хийж

байгаа үйл ажиллагаанууд бүгдээрээ эко системээр бие биетэй, энэ Засгийн газрын яамнуудтай холбоотой ажиллах ёстой. Ган татлага гүүр, тэгээд хиймэл оюун ухаан, хиймэл дагуул мөн нефть боловсруулах үйлдвэр энэ олон төслүүдээ дагасан бид нар боловсон хүчнээ яаж бэлдэж байгаа юм. Энэ томоохон төслүүд хэрэгжүүлээд явлаа гэхэд чинь энэ төслүүдийг дагасан энэ үндэсний томоохон үйлдвэрлэгч компаниуд бий болоод үлдэх ёстой. Ган татлага гүүр барьж чадах ийм чадавхтай компаниуд бий болох ёстой. Энэ хиймэл дагуулыг хөөргөж байгаа энэ үйл ажиллагааг нь удирдах энэ компаниуд бий болох ёстой. Энэ боловсон хүчнээ яаж бэлтгэж байгаа юм. Манай Боловсролын яамнууд, бусад яамнууд энэ эко системээ яаж бэлтгэж байна. Жишээлбэл, Боловсролын яам энэ жил хэдэн яг хиймэл оюун ухаан энэ технологийн салбартай холбогдолтой хүмүүс бэлтгэж байгаа вэ гэх ийм 2 асуултыг асууя.

Ж.Золжаргал: Баярлалаа. Хиймэл дагуултай холбоотой номер 5 микрофон нээж өгнө үү.

Ч.Золбаяр: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний хиймэл дагуул хөөргөх төсөл маань 2011 оноос анх эхлээд, 2010 онд Үндэсний хиймэл дагуулын хөтөлбөр батлагдсанаас хойш үйл ажиллагаа явж эхэлсэн байгаа. Ингээд 2013 оноос хойш Японы Пар Одэко болон Реста компаниудын хамтарсан техникийн эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж, мөн үүнтэй хамтатгаад 14 хиймэл дагуул үйлдвэрлэгч байгууллагуудад урилга явуулж, сонгон шалгаруулалтын ажил явж эхэлснээр энэ хиймэл дагуулын төслийн процесс эхэлсэн байгаа.

Тэгээд энэ тухай бүрдээ ТЭЗҮ болон хиймэл дагуулын сонгон шалгаруулалтын хэлэлцүүлгийн асуудлууд нь сансарын зөвлөлүүдээр тухайн үедээ хэлэлцүүлэгдэж, ҮАБЗ болон Засгийн

газрын хуралдаанаар ороод үе шаттайгаар явж байсан байдаг. Тэгээд энэ юуны хүрээнд хамгийн сүүлд 2023 оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Франц улсад айлчлах үеэр Монгол Улсын Засгийн газар Францын Талс Аленис Бис компанийн хооронд санамж бичиг байгуулагдсан. Хиймэл дагуулын ТЭЗҮ болон гэрээний нөхцөлийг боловсруулах ийм үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг гараад ажилласан байгаа.

Энэ ажлын хэсгийн хүрээндээ Монгол Улсад хуваарилагдсан Ай Пи Өү-ээс хуваарилагдсан хиймэл дагуулын Жи ослот болон радио давтамжийн файлангийн асуудал эд нар тулгуурлан бид нар нөхцөл байдлууд дээр судалгаа хийж, хамгийн сүүлийн боловсруулсан төслийг хамтарч боловсруулж гаргасан. Энэ гаргасан төслийг Францын сансрын агентлаг хянаж үзээд, тэдний гаргасан дүгнэлтийн үндсэн дээр Францын Эдийн засгийн яамнаас Монгол Улсад хөнгөлөлттэй зээлийг олгох ийм шийдвэрийг гаргаж, сандаа Монгол Улсын Сангийн яаманд 3 дугаар сард хүргүүлсэн байгаа. Энэ төслийн хүрээнд бид байгаа боломждоо тулгуурлаж, хамгийн дээд хэмжээний боломжийн ийм саналуудыг хийсэн байгаа. Нарийвчилсан деталь техникийн үзүүлэлтийн хувьд энэ талаар тэр Байнгын хорооны даргад хэлсэн байгаа. Бид нар төслийн 2 талын хамтарсан ажлын хэсэг танилцуулгаа хийхээр бэлдчихсэн байгаа. Энэ хурлын дарга нар энэ нарийвчилсан танилцуулгаа хийхэд бэлэн байгаа гэдгээ хэлье.

Хүний нөөцийн асуудал дээр энэ төслийн хүрээнд хүний нөөцийг үе шаттайгаар сургаж, бэлтгэх ийм багц нь төслийн хүрээнд хамрагдаад орсон. Төслийг хэрэгжүүлэхдээ бид Төрийн өмчит Мэдээлэл холбооны сүлжээ компанийн дэд бүтэц дээр тулгуурлан хэрэгжүүлж, аль болох хөрөнгө оруулалтын зардлыг дотоодын дэд бүтэц байгуулах хөрөнгө зардлыг болон хүний нөөцийн чадамжийг нь тулгуурлан сүлжээ компани дээр хийхээр төлөвлөөд,

хайгуулын ажлууд хийгдээд ингээд явж байгаа.

Тэгэхээр хиймэл дагуул хөөрөөд яг удирдах хэмжээнд 30 гаруй инженер, техникийн ажилтнуудыг бид бэлдсэн байх шаардлагатай. Энд Франц улсад бас сүлжээ компанийн инженерүүд болон энэ төсөл дээр ажиллах сонгогдсон инженерүүд очиж энэ 3 жилийн үйлдвэрлэх процессын хугацаанд бэлтгэгдэнэ.

Мөн энэ төсөл хэрэгжсэний дараагаар нэг жилийн хугацаанд Францын мэргэжилтэн бас Монгол Улсад нэг жилээр ажиллахаар ингэж байж байгаа. Тэгээд энэ хиймэл дагуулын амьдрах хугацаа буюу 15 жилийн хугацаанд Францын үйлдвэрлэгч компанийн зүгээс мэргэжлийн туслалцаа зөвлөгөөг 24/7 цагийн байдлаар өгнө гэдэг байдал бол гэрээний нөхцөлд тусгагдаад ингээд явсан байгаа.

Ж.Золжаргал: Дараа 2 дугаар асуулт дээр нь. Пунсалмаа гишүүн тодруулга хэлье гэж байна. Микрофон нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Миний асууж байгаа асуулт бол яг энэ технологи хамгийн зөв сонголт юм гэдгийг баталчихсан энэ салбарын экспертүүдийн хурлын протокол хуралдсан, эсвэл эрдэм шинжилгээний ямар нэгэн уулзалт хийсэн энэ тайлан дүгнэлтийг харъя. Иргэдийн мэдэх эрхийг хангая. Энэ иргэд мэдэх ёстой. Бид нар бас мэдэх ёстой. Үүнийг хаанаас олж харах вэ гэж асууна.

Ж.Золжаргал: 5 номер нэмэлт хариулт өгье.

Ч.Золбаяр: Энэ төслийн хүрээнд бид Сансрын зөвлөлүүдээр тухайн үед энэ төслийн асуудлуудыг яригдаж байсан протоколууд байгаа гэдгийг хэлье. Яг тусгайлан энэ төсөл дээр бид гаднын экспертийн дүгнэлтийг авсан байгаа.

Тэрийг Францын Сат Консалт компани энэ дээр гэрээний төсөл болон юун дээр гэрээний төсөл болон техникийн үзүүлэлт дээр нь зөвлөгөөгөө өгсөн байгаа.

Мөн Францын Засгийн газрын Сансарын зөвлөлийн агентлаг ирүүлсэн. Бид энэ төслийг боловсруулаад УАБЗ-д танилцуулахаар бэлтгэж байгаа. Энэ танилцуулагдсаны дараагаар бид нөгөө энэ ТЭЗҮ болон энэ төслийн маань бичиг баримтууд нууцын ангилалтай байж байгаа.

Тэгэхээр үүнийг УАБЗ-өөс чиглэлээ авсны дараагаар үүнийг танилцуулна.

Ж.Золжаргал: Нэмэлт хариулт Баатархүү сайд өгнө. Микрофон нээж өгнө үү.

Ц.Баатархүү: Энэ нэлээн хариуцлагатай шийдвэр учраас манай яамны хамт олон, энэ салбарынхан ч гэсэн нэлээн хариуцлагатай хандаж байгаа юм л даа. Тэгээд нөгөө иргэд маань бас мэдэх эрхтэй. Пунсалмаа гишүүний санал 100 хувь зөв.

Тэгээд энэ Байнгын хорооны хурлын араас яг нөгөө төслийн багийн техникийн нарийвчилсан яг гишүүдийн асуух гээд байгаа техникийн хүчин чадал, яг энэ ТЭЗҮ дээрээ юу байгаа юм бэ гэдэг чиглэлээр бас хуралдаанд дэлгэрэнгүй танилцуулга өгье гээд Байнгын хороонд хүсэлт тавьчихсан байгаа. Байнгын хорооны дарга хүсэлтийг хүлээж авсан. Түрүүчийн Байнгын хорооны хурал дээр ч гэсэн гишүүд маань их тодорхой, нарийн нарийн саналуудыг асууж байсан. Хэрэглэгчдийг ямар өгөөжтэй юм, интернэтийн дундаж хурд ямар байх юм, үнэ өртөг нь ямар байх юм гэж байгаа. Яамны зүгээс яг энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийн дунд зөвлөгөөнийг зохион байгуулаад явж байгаа.

2 дугаарт нь маргааш ШУА, шинжлэх ухааны байгууллагууд яг энэ үндэсний хиймэл дагуултай холбоотой хэлэлцүүлгүүдийг хийж байгаа, бид ... /минут дуусав/

Ж.Золжаргал: Энэ Пунсалмаа гишүүний асуусан асуулт дээр би нэмээд хэлэхэд яг ийм мэдээлэл хангалтгүй байгаа учраас Инновац, цахим бодлогын байнгын хорооноос мэдээлэл шаардлагатай байна гээд сонсгол бид нар хийсэн. Өнөөдөр орой дахиад ТЭЗҮ-ийн нарийн тоонуудыг хурлын дараа ажлын шугамаар авч танилцахаар ингээд тогтсон байгаа.

Энэ төслийн төсвийн ерөнхий захиран зарцуулагч нь ЗГХЭГ дээр яваа. Тэгэхээр энэ асуудал бас тэндээ давхар хэлэлцэгдэх байх. Гийшээ зарчмын зөрөөтэй санал, янз бүрийн юм бас орж магадгүй байгаа.

Ингээд энэ дэлгэрэнгүй мэдээллээ дараа нь үргэлжлүүлээд бид нар авна. Баярлалаа.

Ингээд асуулт асууя. Төсвийн, бид нар ингээд энэ цахим шилжилттэй холбоотой салбар болгон дээр байгаа ажлууд дээр санал ямар ажлууд байна вэ гээд ингээд шүүж харсан. Тэгээд ер нь нэлээн их юм байгаа. Би энэ чуулган дээр бас асууж байсан. Тэгээд энэ ажлууд маань Нийтийн мэдээллийн тухай хуулийн 29 дүгээр заалтын дагуу салбарын яамнаасаа зөвлөмж, дүгнэлт авах ёстой. Тэгээд энэ зөвлөмж дүгнэлт авсан уу гээд асуулт явуулсан. Зарим цөөн хэдэн байгууллагуудаас хариу ирсэн байгаа, бусад нь ирээгүй байгаа.

Тэгээд ерөнхийдөө ийм асуулт байна л даа. Би Сангийн сайдаас асуувал зөв юм болов уу гэж бодож байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.4 дээр энэ, би эндээс гаргаад ирье. Төсвийн тухай хуулийн 29.4 хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ

хийгдсэн зураг төсвөө батлуулсан. Хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гээд. Хуульд заасан бусад гэдэг нь нийтийн мэдээллийн систем байгуулахтай холбоотойгоор Нийтийн мэдээллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд, 29 дүгээр зүйлд энэ мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, эдийн засгийн үр ашигтай байдал зэрэг дээр зөвлөмж, дүгнэлт гаргуулна гээд ийм байгаа.

Тэгээд энэ дээр түрүүчийн яамны үед энэ дээр зөвлөмж, дүгнэлт гаргасан, гаргуулсан тийм төслүүд тун ховор юм байна. Нийтийн мэдээллийн системтэй холбоотой салбар болгон дээр ийм төслүүд төсөв дээр тусгагдчихсан байгаа.

Тэгэхээр цаашидаа бид нар ер нь яах ёстой юм бэ? Энэ хуулийн хэрэгжилтийг хянах үүрэг чинь Байнгын хороон дээр байдаг. Тэгээд үүнийг цаашидаа яаж явах вэ гэдэг ийм асуултыг л тавимаар байна.

Баатархүү сайд саяынх дээр хариулт өгөх үү?

Би ингэж асуугаад байна л даа. Энэ төсвийн тухай хууль дээр төсөв, ТЭЗҮ эсвэл бусад ийм тодорхойлолт байх ёстой гээд заачихсан байдаг. Бусад гэдэг нь нөгөө салбарынхаа Нийтийн мэдээллийн тухай хууль дээр болохоор яамнаас зөвлөмж, дүгнэлт авах ёстой гээд заачихсан байдаг. Тэгээд зөвлөмж, дүгнэлтээ авдаггүй. Авахгүйгээр төсөвтөө ороод ирчихсэн байдаг ийм л юмнууд яваад байна л даа.

Жавхлан сайдын микрофоныг нээж өгнө үү.

Б.Жавхлан: Золжаргал даргын асуултад хариулъя. Ингэж байгаа юм. Та хөрөнгө оруулалт талд нь асууж байх шиг байна. 9 сарын 1-нд бид ирэх оныхоо төсвийг өргөн барьдаг. 9 сарын 1 хүртэл төлөвлөлт хийхдээ үндсэндээ бид

хөрөнгө оруулалтынхаа саналыг шинэ цаглавраараа ер нь 6 сарын 15 гэхэд аваад дуусдаг байхгүй юу. Системдээ оруулаад. Тэр болтол төсвийн ерөнхийлөн захирагч нар оруулж байгаа төсвийн хөрөнгө оруулалт, төсөл бүр дээрээ өөрсдөө чиглэл чиглэлээрээ дүгнэлтээ хийгээд, эрэмбэлээд гаргасан журам байгаа юм. Түүний дагуу бүгдээрээ бэлтгээд ингээд системд оруулж байгаа. Системд оруулахад тэнд чинь бараг 30, 40 асуултууд байгаа. Түүн дотор таны саяын ярьж байгаа энэ тэр шаардлагуудад нийцсэн асуултуудад хариулаад, хариулаад бөглөөд, цааш нь явуулаад ингээд яам руу, Сангийн яам руу, Төсвийн нэгтгэл рүү илгээдэг байгаа. Түүгээр таны саяын асуусан асуулт баталгаажна гэсэн үг.

Харин ингээд төсөв өргөн баригдсанаас хойш хэлэлцэх, батлах шатад Улсын Их Хурал дээр бас нэлээдгүй төслүүд орж ирдэг. Нэлээдгүй төслүүд бас өргөн баригдсанаас хойш хасагддаг ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр яг Улсын Их Хурал дээр өргөн баригдаад юу, өргөн баригдсанаас хойш хэлэлцэх шатад гишүүдийн гаргаж байгаа зарчмын зөрөөтэй санал, энэ тэртэй холбоотой орсон төслүүд дээр Засгийн газар хариулт байхгүй. Тийм. Улсын Их Хурал дээрээс батлагдсан төслийг тэгээд л бид нар хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэнд зураг төсөвгүй ч юм уу ороод ирдэг, янз янзын л юм ороод ирдэг. Энэ жил жишээ нь одоо 88 төсөл тендерээ зарлаж чадаагүй байж байгаа. Зураг, төсөл нь эцсийн байдлаар магадлан хийгдээгүй ийм төслүүд байж байгаа. Эдгээр төслүүдийн ихэнх нь жишээ нь Засгийн газар өргөн баригдсанаас хойших төсөл дээр нэмж ороод батлагдсан төслүүд байх жишээтэй. Тийм.

Тэгэхээр тийм, системээр орж ирж байгаа хөрөнгө оруулалтын төслүүд бол бүх шаардлагаа хангаад орж ирж

байгаа гэдэг дээр бүрэн хариуцлага хүлээнэ.

Ж.Золжаргал: Тэр системээр орж ирж байгаа, орж ирсэн төслүүд нь шаардлага хангаад, яамнаасаа зөвлөмж, дүгнэлтээ авсан эсэх тал дээр Баатархүү сайд нэмэлт хариулт өгөх үү. 4 номер Алтан-Од дарга хариулт өгнө.

П.Алтан-Од: Гишүүний асуултад хариулъя. Төсвийн цаглавартай уялдуулаад төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөв өргөн барихдаа яамнаас санал авсан. Одоогоор 6 төсвийн ерөнхийлөн захирагчийн санал дээр яам салбарын байгууллагууд маань хариулт өгсөн. Соёлын яам, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, ЗТХ-ийн яам, Жендерийн үндэсний хороо, Цахим хөгжил, инновацийн яам, Гадаадын иргэн харьяатын газар гэсэн газрууд яг ингээд бие даасан системийнхээ асуудал дээр зөвлөмж, дүгнэлт авч манайхаас хүргүүлсэн байгаа.

Ж.Золжаргал: 6 байгууллага гэсэн тийм ээ, 6 ерөнхийлөн захиран зарцуулагч.

Тэгээд одоогоор, энэ асуултыг бас тус бүрд нь явуулсан байгаа юм. Тэгээд хариу цөвхөн хэдэн байгууллагаас ирсэн. Инновац, цахим бодлогын байнгын хороо хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй учраас энэ асуудал дээр бид нар бас энэ төсвөөс тусдаа хуралдаж ярилцана. Тэгээд магадгүй энэ нийцлийн аудитын асуудал бас яригдаж болох юм гэж харж байгаа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Үүг хэлэх гишүүн Цэнгүүн гишүүнээр тасаллаа.

Цэнгүүн гишүүний микрофон нээж өгнө үү.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан дээр 1,9 тэрбумыг тавьчихсан байгаа юм. Тэгээд яг ингээд харахаар Цахим хөгжил, инновацын яам дээр байх яг үндсэн хийх ажил нь мөн үү гээд харахаар хүнсний аюулгүй байдлын талаарх контент, тэгээд хорт зуриил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх тухай контент гээд 25 минутаас дээш байх ийм шаардлага тавьчихсан ийм контентуудыг бүтээхийн төлөө энд ингээд мөнгө тавьчихсан байна л даа.

Тэгэнгүүт Монголын Үндэсний Телевиз ер нь энэ ажлыг нь хийгээд явчхаж болдоггүй юм уу. Айл болгон л энд чинь сар болгон төлбөрөө төлөөд, Монголын Үндэсний телевиз чинь энэ асуудлаа хийгээд явна л гээд бид нараас мөнгө авч байгаа шүү дээ. Тэгээд ингээд хараад үзэхээр үнэхээр бид нар чухал ач холбогдолтой зүйлүүд дээр улсын төсөв гаргахгүйгээс болоод бид нарын Монгол Улсын хөгжил өөрөө гагцхиаад байгаа юм.

Тэгэхээр энэ эрчим хүчний реформыг бид нар хийе гээд ярихаар үнэ тарифтай холбоотой асуудал зайлиггүй яригдахаас өөр аргагүй. Яагаад гэвэл үнэ тарифын тухай асуудлыг шийдэж байж, бид нар хөрөнгө оруулагч нарыг татаж, шинэ төслүүдээ, шинэ эх үүсвэрүүдээ гаргаж явахаас өөр аргагүй бодит байдалд тулчхаад байгаа юм. Тэгээд үүнийгээ гаргаж ирэх гэхээр манай иргэд ойлгож байгаа. Мэдээж хэрэг цахилгаан станцууд дээр хүнд асуудал байна. Гэхдээ та нар наад төсөв дээр байгаа үрэлгэн зардлуудаа хасаач ээ, бид нарын татварыг багасгаач гэдэг л шаардлага тавьж байгаа шүү дээ.

Тэгээд өнөөдөр яг төсөв яриад ингээд сууж байхад бид нар ийм сонин утгагүй сангуудыг хөрөнгө оруулалтуудыг нь шийдээд л, Соёл урлагийн дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан, энэ Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх сан гээд энэ хамааралгүй

асуудлуудыг бид нар дэмжиж явуулснаас болоод иргэд маань бухимдал үүсээд байгаа шүү дээ.

Тийм учраас бид нар ер нь цаашидаа энэ асуудлуудыг цэгцлээд, дараачийн байдал дээр үнэхээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад орчихсон байгаа энэ маань яг тэр инновацтай холбоотой, яг тэр технологитой холбоотой зүйлдээ хэрэглэгдэж байгаа юм уу гэдгийг хянадаг баймаар байна.

Дээрээс нь бас үүнийг зохих талын асуудлуудыг бас Баатархүү сайд маань хийгээсэй гэж хүсэж байна.

Ж.Золжаргал: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо зарчмын зөрөөтэй санал, асуултууд дээр санал хураалт явуулъя. Тэгээд 3 гишүүнээс 4 зарчмын зөрөөтэй санал ирсэн байна. зарчмын зөрөөтэй саналыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Хосбаярын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах /Улсын хэмжээнд/ төслийн төсөвт өртөг 4 тэрбум төгрөг, санхүүжих дүн 4 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 17.1.3.1-д тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж төсөвт өртөг 24 тэрбум төгрөг, санхүүжих дүн 24 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 4 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн байна.

Асуулт асууя, тийм ээ. Засгийн газрын гишүүд тайлбар авч болно. Тэгээд

Номин сайд тайлбар өгнө. Микрофон нээж өгнө үү.

Ч.Номин: Сайн байцаана уу. Дахиад энэ ингээд соёлын салбар гэхээр л бүх хүний нүдэнд хорсол төрөөд байдаг юм шиг байгаа юм. Соёл гэдэг чинь хүнийг хүн болгодог шүү дээ. Бид нар байшин, барилга барьж болно, зам тээвэр тавьж болно. Гэхдээ хүний оюун санаатай ажилладаг, хүнийг ёс зүйтэй байлгах, хүнийг хүн болгодог зүйл чинь соёл байгаа юм. Тэгээд соёлын салбар дээр юм ороод ирэхээрээ л хаанаас гаргах вэ гэхээр соёлын салбараас л гаргая гэж боддог юм шиг байгаа юм. 24 тэрбум төгрөг нь их харагдаад байж магадгүй. Манай салбар ерөөсөө нийлээд байгаа дүн нь нийт төсвийн зарцуулалтын 1,7 хувьдаа ч хүрэхгүй байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний 0,6 хувь байгаа. Олон улсын хэмжээнд хүнийг хүний оюун санаатай ажиллахдаа хамгийн багадаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 1-5 хувийг зарцуулдаг. Тэгж байхад л хаана танах вэ гэхээрээ соёлын салбараас хайгаад байдаг.

Нөгөө талаас нь төсөв талаас нь ярихад бид бүхэн өнгөрсөн 4 жилийн хугацаанд 80 гаруй бүтээн байгуулалтыг ашиглалтад оруулсан. Тэгэхээр энэ бүтээн байгуулалтыг ашиглалтад оруулсан учраас цаашаа бид нарыг энэ үр өгөөжтэй, үйл ажиллагаатай байлгахын тулд дотор тоног төхөөрөмжийг нь бүрэн байлгаж байж, тэнд үйл ажиллагаа явна. Үйл ажиллагаа явна гэдэг чинь хүнд хүргэх, хүний хүнд соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлууд явагдана гэсэн үг.

Тэгэхээр энэ 24 тэрбум төгрөг чинь нийтдээ 485 байгууллагад үйл ажиллагаа явж байгаа, орон нутагт байгаа болон нийслэлд байгаа үйл ажиллагаа явуулж байгаа соёлын орон зайнуудад зарцуулагддаг буюу музей, номын сан, соёлын төв, театр гээд олон зүйлүүд дээр хуваарилагддаг. Түрүүний хэлсэн 80 гаруй шинээр ашиглалтад

орсон бүтээн байгуулалтуудын тоног төхөөрөмж байгаа юм.

Тэгэхээр энэ гишүүд нэг хаанаас мөнгө олох вэ гэхээрээ л хамгийн түрүүнд хүнтэй ажилладаг, хүний хөгжилтэй ажилладаг зүйл рүүгээ дайрахаа болимоор байна. Үүнийг бас бодолцож үзмээр байна.

Нөгөө талдаа сайхан байшин дотор байгаад, ёс зүйгүй, хүмүүжлийн доголдолтой хүмүүс байх юм бол өнөөдөр бид нар хамтаар амьдрах нөхцөл байдал үүсэхгүй ээ. Өнөөдөр гараад хүмүүсийг хэлэхдээ юу гэдэг вэ гэхээр энд гадаа явж байгаа хүмүүс ямар соёлгүй юм бэ, бие биетэйгээ машины цаанаас яасан муухай харьцдаг юм бэ гээд. Энэ чинь юу вэ гэхээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд яг ийм нөхцөл байдлаар соёлын салбартаа хариуцлагагүй хандсанаас үүдэж гарч ирж байгаа зүйл ээ. Цаашид тодорхой түвшинд бид нар хүний хөгжилдөө зориулсан зүйлдээ мөнгө төгрөгөө зарцуулах хэрэгтэй.

Тэр түрүүний хэлээд байгаа контентууд чинь бид нар олон улсын соёлын нөлөөлөлд автаж байна. Хүүхэд, залуучууд чинь энэ олон платформоор дамжиж өөрсдийнхөө мэдлэгийг авч байна.

Тийм учраас бид нар өнөөдөр энэ яриад байгаа Монгол хэл, соёлоо сурталчлах, Монгол хэл, соёл дээрээ гарч байгаа контентуудыг бий болгож байж, дэлхийд өрсөлдөх тэр анимэйшнүүдийг чинь гаргаж ирж, хүүхдүүд үзэж байж, энэ соёлтой чинь харьцаж, өв соёлоо мэдэж, Монгол хүн болдог юм. Тэгэхээр энэ соёл руу л юм л орохоо болимоор байна энэ гишүүд, одоо.

Ж.Золбаяр: Энэ саналтай холбоотой Баатархүү сайд нэмэлт мэдээлэл үндэслэл талаар өгөх үү? Хэрэгцээ шаардлагын талаар. Үг хэлэх үү. Өөрөө байхгүй байна л даа. Хосбаяр.

Хэлэхгүй байж болно. Цахим хөгжил, инновац, харилцаа холбоотой холбоотой гэдэг утгаараа.

Хосбаяр гишүүнээс гаргасан зарчмын зөрөөтэй санал. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багц дээр оруулах гэсэн тийм санал байгаа.

Санал хураалт явуулъя.

Саяын Хосбаяр гишүүний ирүүлсэн саналын томъёоллоор, зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал дэмжигдсэнгүй.

Дараагийн 2 дахь санал.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргалын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Аймгуудын цахим ишлжилтийг эрчимжүүлэх төслийн төсөвт өртөг 5 тэрбум төгрөг, санхүүжих дүн 5 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг Төслийн 2 дугаар хавсралтын 18.1.1-д тусгагдсан Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, төсөвт өртөг 213 тэрбум төгрөг, санхүүжих дүн 213 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 5 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн ийм саналын томъёолол байна.

Энэ саналын хувьд аймгуудын “цахим аймаг” гэсэн хөтөлбөр ингээд жил гаруй хэрэгжээд явж байгаа. Тэгээд одоогоор энэ 7 аймаг дээр нэмэлт цахимжилтыг хэрэгжүүлэх шаардлага үүссэн. Энэ нь болохоор Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ийм

ажлууд байгаа. Тэгээд энэ төсөвт хөрөнгийн хувьд 5 тэрбум төгрөгийн төсвийг сугалъя гэсэн ийм зарчмын зөрөөтэй санал байна.

Энэ зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

70 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн 25 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх хөтөлбөр төслийн төсөвт өртөг 2.59 тэрбум төгрөг, санхүүжих дүн 2.59 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг төслийн 2 дугаар хавсралтын 17.1.3.1-д тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж, төсөвт өртөг 24 тэрбум төгрөг, санхүүжих дүн 24 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 2.59 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн ийм саналын томъёолол байна.

Энэ дээр холбогдох Номин сайдын микрофоныг нээж өгнө үү.

Ч.Номин: Төсөл, арга хэмжээнээс хөтөлбөр арга хэмжээ рүү хуулийн дагуу ишлжүүлж болох юм уу. Наадах чинь үгүй ээ, хөтөлбөр байна шүү дээ. Нэг нь инновацад зориулсан хөтөлбөр, нөгөөдөх нь болохоор төсөл, арга хэмжээ байна шүү дээ. Нэг нь хөрөнгө оруулалт нэг нь юу, хоёулаа хөрөнгө оруулалт юм уу?

Би түрүүн бас хэлсэн. Дахиад хэлье. Энэ бол манай соёлын салбарт

нийтдээ 80 гаруй байгууллага ашиглалтад орж байгаа музей, тэгээд номын сан, хүүхдийн хүүхэд залуучуудад зориулсан соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх олон төсөл, арга хэмжээнүүд орж байгаа. Тэгээд мэдээж би инновацын салбарт хөгжил авчрах нь зүйтэй гэдгийг ойлгож байгаа. Шинэ технологиудыг оруулж ирэх нь зүйтэй гэдгийг ойлгож байгаа.

Гэхдээ энэ зүйлээ энэ салбар хоорондоо шилжүүлэлт хиймээр байна. Бусад салбар луу ингэж орж бас л энэ соёлын салбар дээр чинь үйл ажиллагааг тогтмолжуулах гээд зардал нь тавигдсан байгаа. Тэгэхээр энэ зардал руу давж орохгүй байхыг хүсэж байна.

Ж.Золжаргал: Энэ дээр түрүүн бас нэмэлт тайлбар өгье гэсэн. 4 дүгээр микрофоныг нээж өгье. Соёлын салбарын төсвөөс зөвхөн нэг хэсэг дээр нь гэсэн санал. 4.

П.Алтан-Од: Улсын Их Хурлын саяхан баталсан 25 оны жилийн төлөвлөгөө дээр Нотариатыг цахимжуулах гэж, мөн хиймэл оюун ухаан их өгөгдлийг ашиглан төрийн инновацыг хөгжүүлэх гэдэг заалтууд туссан. Бид нар Сангийн яам руу холбогдох төсвийн цаглаврынхаа хүрээнд саналуудаа томъёолоод хүргүүлсэн болов чиг хасагдсан байгаа. Их Хурлын гишүүд өөрсдөө Их Хурлын чуулган дээр жилийн төлөвлөгөө батлахтай холбогдуулаад өөрсдөө санал санаачилга гаргаж, батлуулсан заалтууд байдаг. Мөн яамнаас тайлбар зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг нь холбогдох баримт бичгийг нь хугацаанд нь хүргүүлсэн байдаг.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны хувьд бас зарим саналуудыг дэмжээд хамтраад хэрэгжүүлэх салбар дундын зохицуулалттайгаар явах ийм манай яам бусад яамтай ингэж хамтарч ажиллахаар ийм олон зохицуулалтын юунууд байгаа.

Тэгэхээр та бүхэнд бодож бас дэмжиж өгөх нь хүсье.

Ж.Золжаргал: Санал хураалт. Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

40 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд сүүлчийн 4 дэх санал.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргалын гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Төслийн 2 дугаар хавсралтын 20 дахь хэсгийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24тп” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх төслийн төсөвт өртөг 1.2 тэрбум, санхүүжих дүн 1.2 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих эх үүсвэрийг Төслийн 2 дугаар хавсралтын 7.4.1-д тусгагдсан Авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, төсөвт өртөг 15 тэрбум 645 сая төгрөг, санхүүжих дүн 15 тэрбум 645 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний дүнг 1.2 тэрбум төгрөгөөр бууруулах замаар гаргах гэсэн ийм санал байна.

Энэ санал дээр энэ төслийг хэрэгжүүлж байсан ХХЕГ-ын ерөнхий командлагч мэдээлэл өгөхөөр ирсэн байгаа. Байхгүй байна. Золбоо зөвлөх тэр ирсэн байна уу, лавлаад өгөх үү? Нэмэлт мэдээлэл өгнө гэсэн.

Тэгээд би өөрийнхөө зүгээс мэдээлэл өгье. Монгол Улсын хэмжээнд саяхан та бүхэн бас санаж байгаа байх. Нөгөө Япон-Монголын хамтарсан эмнэлэг рүү цусны дрон цусны юуг дронуур хүргэсэн тийм үйл явдал болсон. Тэгэхээр дроны хэрэглээ иргэний хамгаалал, нийгмийн бүх салбарт шуудан

зөөх, тэгээд л нөгөө ойн хортон шавжтай тэмцэх гэх мэтчилэн хамгийн их хэрэглээтэй нь хил хамгаалах байгууллага. Хил дээр дроны хэрэглээ сүүлийн хэдэн жил маш их нэмэгдсэн. Өргөн ашигладаг. Энэ үүднээс дрон хөгжүүлээд, прото табыг нь үйлдвэрлээд, гаргаад, хэрэглээд туршичхсан ийм төсөл явж байгаад олон улсын дэмжлэг авах гэж явж байгаад тэгээд дэмжигдээгүй. Хэрэгжүүлсэн боловсон хүчин, баг, суурь дэд бүтэц нь бэлэн болсон ийм байгаа.

Тэгэхээр энэ инновацын хөгжлийн харилцаа холбоо ч тэр, инновацын ч тэр, чухал энэ том том дүн төсөв ярьж байгаа үед бэлэн болоод үйлдвэрлэчихсэн зүйлийг нэвтрүүлээд, эхний жилдээ төслийн танилцуулгаар 7 дроныг үйлдвэрлэх юм гэнэ лээ. Тэгээд 7 дрон үндсэндээ одоо худалдаж аваад, хэрэглэж байгаа тэр дроны ханшаар бодоход зардлаа хангахдаа нөхчихөөр ийм зүйл байгаа.

Тэгээд цаашидаа тоног төхөөрөмж нь, үйлдвэрлэлийн суурь машин нь үлдээд ингээд төсөл үргэлжлээд хэрэгжээд явна гэсэн ийм мэдээлэл байгаа.

Тэгээд үүнийг авто замын нэвтрүүлэх хурдцыг сайжруулах, ТЭЗҮ боловсруулах, зураг төсөв 15 тэрбум төгрөгийн төсвөөс 1,2 тэрбумыг нь буюу материалын зардал, тоног төхөөрөмж худалдан авах, тэгээд ажиллах инженерүүдийн цалин гэсэн ийм төсвөөр бууруулах гэсэн ийм зарчмын зөрөөтэй санал гаргаж байгаа юм.

Нэмэлт мэдээлэл өгөх хүн ирээгүй юм шиг байна. Ирээгүй байна уу, тийм ээ.

Ингээд энэ Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Золжаргалын гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор саналыг

дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

70 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа.

Санал хураалт явагдаж дууслаа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа Төсвийн байнгын хороонд уншиж танилцуулна.

Баярлалаа.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

17.35 цаг

Одоо хуралдаан хаасан. Хуралдааны дараа гишүүд хиймэл дагуулын талаар дэлгэрэнгүй ТЭЗҮ-ийн мэдээлэл танилцуулах учраас та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ